

- 52 айлын үйлчилгээтэй нийтийн орон сууцны төсөл,
20 айлын амины орон сууц зэрэг төслүүдийг
хэрэгжүүлж иргэдийн тав тухтай орчинд ажиллаж
амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.



**ГАЗАР ОЛГОЛТ, БИЗНЕСИЙН ОРЧИН, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРТ
ХАМРАГДАХ БОЛОМЖ, ТӨРИЙН АЛБАНХААГЧДЫН ЦАЛИНГИЙН
НЭМЭГДЭЛ:**

Иргэдэд үнэгүй өмчлүүлэх 0.07 га газар олгох боломжит байршлуудыг тодорхойлсон ба инженерийн шугамд холбож шинэ суурьшлын бүсүүдийг төлөвлөөд байна. Мөн сум орон нутгийн бизнес эрхлэгчдэд Хоршоо хөгжүүлэх сангаас болон Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт хамруулан урт хугацааны бага хүүтэй зээлийг олгон дэмжин ажиллаж байна.

Төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлийн хувьд төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 60 хувь, төрийн үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 40 хувь олгогдож байна. Цаашид орон нутгийн нэмэгдлийг 100 хувь болгох зорилготой ажиллаж байна.



САЙХАН СУМ



НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ



“СЭЛЭНГИЙН ИРЭЭДҮЙ- ТОГТВОРТОЙ НОГООН ХӨГЖИЛ”


САЙХАН СУМЫН ОНЦЛОГ

Сэлэнгэ аймгийн Сайхан сум нь Атар газар эзэмших 2 дахь аянаар 1976 онд үндсэн сууриа тавьсан. Номгон сангийн аж ахуйг түшиглэн БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 03-р сарын 26-ний өдрийн 64-р зарлигаар байгуулагдсан.

1980-аад онд илгээлт өвөртлөн ирсэн нутаг нутгийн залуучуудаас бүрдсэн бөгөөд төв зам, төмөр зам дагуу байрлах, дэд бүтэц сайтай, газар тариалан, үйлдвэрлэл хослон хөгжсөн онцлогтой Сэлэнгэ аймгийн баруун бүсийн 5 сумдын төв юм.

Сумын хэмжээнд Ерөнхий боловсролын 3 сургууль, Сургуулийн өмнөх боловсролын 4 цэцэрлэг 2224 гаруй хүүхэд багачуудад боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж байна.

Бодлогын түвшинд 10,000+4 аян өрнүүлэх, МСҮТ, Хүүхэд харах үйлчилгээний газар,



91116312



<http://Saikhan.se.gov.mn/>



Аж үйлдвэрийн чиглэлээр Барилгын материалын ЖДҮ, Жимс жимгэсний брэнд гаргах.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: ХАА-н тоног төхөөрөмж, сэлбэг, хор бордооны худалдаа, Эрчимжсэн мал аж ахуй, Малын бойны төв

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Зоогийн газар, Зочид буудал, Авто угаалга, Тоглоомын төв, Номын сан зэрэг бизнесийн боломж бололцоо их ба орон нутгийн хөгжлийн сангийн зээл, Старт апп хөтөлбөр мөн бодлогын түвшинд өрхийн амьжиргааг дэмжин “Өрх бүр – Ажлын байр” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн Сайхан сум, Хөтөл хот нь үйлдвэрлэл дэд бүтэц сайтай газар тариалан, мал аж ахуй хослон хөгжсөн, 15000 орчим хүн амын төвлөрөл бий болсон суурин юм. Өнөөдрийн байдлаар 28 төрийн болон орон нутгийн өмчит томоохон байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн Сайхан сум нь Сэлэнгэ аймгийн баруун бүс болох Орхон, Орхонтуул, Сант, Баруунбүрэн сумдын төв гэдгээрээ бүх төрлийн бизнес эрхлэх бүрэн боломжтой.

Сумын нутаг дэвсгэр дээгүүр хүн тээвэр, ачаа тээврийн төмөр зам дайран өнгөрдөг ба Дархан- Эрдэнэт чиглэлийн улсын чанартай хатуу хучилттай 44 км авто зам, хотын төвдөө орон нутгийн өмчийн хатуу хучилттай 3,2 км авто зам, Номгон 3-р багт 1,4 км хатуу хучилттай болон сайжруулсан хөрсөн зам ашиглагддаг.



ЦАХИЛГААН ХАНГАМЖ:

ДСЦТС-ний харьяа төвийн эрчим хүчний системд бүрэн холбогдсон. Орхон сумаас Номгон 3-р багийн чиглэлтэй 110/23,8/10квт-ийн дэд станцтай.

ДУЛААН ХАНГАМЖ:

Сумын төвд “Цемент Шохой” ТӨХК-ийн харьяа босоо халаагуурт 3зуухбүхий20Гкал/цагхүчинчадалтай,дулааны станц ажилладаг бөгөөд Номгон 3-р багт “Гавшгай Ус” ОНӨААТҮГ-ын харьяа 1дулааны уурын зуух ажиллаж байна.

ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖ:

Сумын хэмжээнд инженерийн бүрэн хангамжтай 1370 айлын 5-6 давхар бүхий 30 орон сууц байгаа бөгөөд бусад нь амины орон сууц, гэр сууц юм.

УСАН ХАНГАМЖ:

Сумын төвд орон нутгийн өмчит “Гавшгай Ус” ОНӨААТҮГ цэвэр усны эх үүсвэрийн 19 худаг камер бүхий,12 км урт дулаан хангамж 10.8 км хэрэгцээний халуун ус, 11,4 км цэвэр усны шугам сүлжээ тоног төхөөрөмжтэй. 22 км зайнаас усаа олзворлодог, 2000м3 багтаамжтай 2

усан сан, хоногт 5000-6000 м3 ус олдворлодог 4 өргөх станцтай, гэр хорооллын 500 өрхийг хангадаг 4 зөөврийн худагтай. Төвлөрсөн ус хангамжийн системд 1500 гаруй өрх, 80 гаруй ААНБ холбогдож бусад айл өрх 4 ус түгээх байрнаас усаа авч байна.

Цэвэрлэх байгууламж:

Хоногт 3500 м3 ус цэвэршүүлэх хүчин чадалтай. 30 орон сууцны болон албан байгууллагуудын 2700-3000 м3 ус цэвэршүүлж, нууршуулах талбайд хийдэг цэвэрлэх байгууламжтай.



СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ:

Аж үйлдвэрлэл болон дэд бүтэц сайн хөгжсөн, газарзүйн байршлын хувьд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудын дунд байрлах бөгөөд авто болон төмөр замаар холбогдсон 15000 орчим хүн ам төвлөрсөн аймгийн зэрэглэлтэй хотын статустай бүх төрлийн тэр дундаа барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх, худалдаа үйлчилгээний чиглэлээр бизнес эрхлэх бүрэн боломжтой суурин юм. Мөн хөдөө аж ахуйн чиглэлээр эрчимжсэн мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд цаг уур, орчин нөхцөлийн хувьд тохиромжтой

ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ БОЛОН ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АЖИЛ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ:

Манай сум нь 2019-2029 оны сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд “Аж үйлдвэр, газар тариалан, мал аж ахуй дэд бүтэц, үндэсний эрүүл хүнс, үйлдвэрлэлтээрээ аймаг болон улсдаа тэргүүлэх, төрийн байгууллагаас иргэддээ үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг ил тод нээлттэй болгох, нутгийн удирдлагын байгууллагын бүтцийг оновчтой зохион байгуулах” зорилго тавьж дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Төмөрхайлуулахүйлдвэр,Барилгынматериалын үйлдвэр.Сүүсүүнбүтээгдэхүүнбяслагийнүйлдвэрээрэг үйлдвэрлэлийг байгуулж ажлын байрыг нэмэгдүүлэх.
- “Шинэ Хөтөл” шинэ суурьшлын бүсийг байгуулж 400 айлын Шинэ Хөтөл орон сууцны хороолол төсөл.